



# СОЁМБО МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№113 /557/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.07.21

Цаг үе, үйл явдал

## "НЭГ ЗАМ-НЭГ СОЁЛ" АЯНД НЭГДЛЭЭ



Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албанаас зам тээврийн осол, хэргийн улмаас хүний амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах, замын хөдөлгөөний соёлыг төлөвшүүлэх зорилгоор улсын хэмжээнд "НЭГ ЗАМ-НЭГ СОЁЛ" нөлөөллийн аяныг эхлүүлсэн билээ.

"Орон нутгийн соёл-2023" нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохиогдож буй тус аянд ЗХЖШ болон Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба нэгдлээ.

Энэ хүрээнд "Нэг зам-нэг соёл"-аяныг замын хөдөлгөөнд оролцож буй жолооч, явган зорчигчдод сурталчлан таниулах зорилгоор хөгжимт парадыг

өнөөдөр зохион байгууллаа.

Цагдаагийн байгууллагаас өнгөрсөн онуудад хэрэгжүүлсэн "Яараад яахав дээ", "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" зэрэг ухуулга, нөлөөллийн аяны үр дүнд зам тээврийн ослын тоо 8-50 орчим хувиар буурчээ.

Иймд энэ удаагийн аянд ч тээврийн хэрэгслийн ард суусан жолооч бүр нэгдэж, замын хөдөлгөөнд соёлтой оролцох, хариуцлагаа нэмэгдүүлэх, дүрмийн талаарх ойлголт мэдлэг, хандлагаа дээшлүүлэх, бусдын амь нас, эд хөрөнгөнд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулахыг Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас уриалж байна.

## БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГҮҮД ИРГЭДИЙН АМЬ НАС, ЭД ХӨРӨНГИЙГ ҮЕРИЙН АЮУЛААС АВРАН ХАМГААЛЛАА



"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Барилга-инженерийн цэргийн удирдах газар, "Смарт Эко транс" ХХК-тай хамтран Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гашуунсухайт боомтод "Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал"-ийг барих төсөлд оролцож байгаа билээ.

Энэ сарын 21-ний өдөр Ханбогд суманд түр зуурын хүчтэй аадар бороо орж, байгалийн хүнд нөхцөл үүсэхэд тухайн газар оронд ажиллаж буй бие бүрэлдэхүүн өөрийн техник, хүн хүч, хэрэгслийг богино хугацаанд осол, эндэлгүйгээр татан авч, байршууллаа.

Энэ үед шөнийн 23 цагийн орчим Pruis 20, Pruis 30 маркийн автомашинтай Ханбогд сумын Хайрхан багийн 7 иргэн, 3 настай хүүхэд үерийн урсгал руу орж, боогдон живж байсныг цаг алдалгүй тусламж үзүүлж, авран хамгааллаа.



Үерт боогдсон иргэдийг Ковш автомашины шанаганд суулган аюулгүй газар шилжүүлж, 2 нэгж техникийг чирч, үерийн уснаас татан гаргаж тусламж үзүүлэн, болзошгүй аюул ослоос хамгааллаа.

Тухайн аврах ажиллагааг явуулж байх үед үерийн усны гүн 0,6-1,7м хүрч, үерийн усанд замын боржуур урсан хөвж байв.

Барилга-инженерийн цэргүүд эх орныхоо энэ цагийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудад оролцохын зэрэгцээ болзошгүй аюул гамшгийг арилгахад дэмжлэг үзүүлж оролцож байгаад нутгийн иргэд баярлаж, талархал илэрхийлж байсан юм.

Түүгээр зогсохгүй энэхүү байгалийн давагдашгүй нөхцөл байдал бүтээн байгуулалтын ажлын чанарыг шалгасан сорил байсныг амжилттай даван тууллаа.

Төслийн гүйцэтгэгч хурандаа Б.Бодьхүү даргатай төслийн удирдлагын нэгж, хурандаа У.Буянжаргал захирагчтай Зэвсэгт хүчний 340 дүгээр анги, хурандаа Ц.Амарсайхан захирагчтай Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн бие бүрэлдэхүүн цаг агаарын хүнд ширүүн нөхцөлд, цаг хугацаанд нь чанартай үүргээ гүйцэтгэн ажиллаж байна.

Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийг Үндэсний их баяр наадмын өмнөхөн Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн ээлжит хуралдаанаар Улс орныхоо хөгжил цэцэглэлтэд бодит хувь нэмэр оруулж байгааг онцлон ажил үйлсийг нь өндрөөр үнэлж, "Баяр хүргэж" сайшаасан бол "Смарт Эко транс" ХХК гүйцэтгэгч байгууллагуудаас онцлон ангиудад автомашин, бие бүрэлдэхүүнд 100,000-700,000 төгрөгийн урамшуулал олгосон зэрэг нь бүтээн байгуулалтад оролцож буй бүрэлдэхүүний урам зоригийг бадраасан явдал болсон юм.

Барилга-инженерийн цэргүүд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын ажил, Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км төмөр замын бүтээн байгуулалт, Дорнод аймгийн Халх гол суманд хэрэгжсэн "Шинэ сум" төсөл, Дарханы авто замын ажил зэргийг чанартай сайн гүйцэтгэж байсан туршлагатай хамт олон билээ.

Барилга-инженерийн цэргүүдэд бүх талын дэмжлэг үзүүлж ажилладаг Батлан хамгаалах яам, ЗХЖШ, төрлийн цэргийн командлалын нийт бие бүрэлдэхүүнд талархаж байгаагаа илэрхийлэе.

БИЦУГ



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 37	🌧️ 23

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,429	3,437
EUR 🇪🇺	3,810	3,830
CNY 🇨🇳	479	484
RUB 🇷🇺	38,10	38,30
JPY 🇯🇵	23.30	24.80
KRW 🇰🇷	2.63	2.65

### ЗУРХАЙ



2023.07.21 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 4

**ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААН ЛУУ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**Бие эрхтний хүч сайжирна**  
**Наран ургах, шингэх:**  
**05.15-20.42**  
**Барилдлага:**  
Түлэх  
**Шүтэн барилдлага:**  
САНСАР

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олно.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,600,489

Эдгэрсэн

Нийт: 664,200,023

Нас барсан

Нийт: 6,903,890

Цахим шууданд

# АХЛАХ БАЙЛДАГЧ Б.ЛХАГВАДОРЖ: БИДНИЙ НЭГНЭЭ ГЭСЭН СЭТГЭЛ ИХ ДУЛААН



баталгаажуулснаар өдгөө хугацаат цэргийн албаа үргэлжлүүлэн хааж байна. Их сургуульдаа бүрэн тэнцсэн тухай баярт мэдээтэй эргэн ирэхэд тус ангийн удирдлага, үе тэнгийн найзууд нь хэрхэн хүлээн авсан бол ...

-Тэд маш их баяртай хүлээж авсан. Салаа, рот, ангийн захирагч нар хүлээн авч баяр хүргэсэн. Хугацаат цэргийн алба хаагчид маш их баяртай байгаагаа байнга илэрхийлсээр байна. Сургуульдаа бүртгүүлж, шалгалт өгч байх явцад өөр шиг тань хугацаат цэргийн албанаас их сургуульд элсэж байгаа байлдагч харагдав уу? -Миний анзаарснаар Хилийн цэргийн хоёр байлдагч байсан. Тэд цэргийн дүрэмт хувцастайгаа ирсэн байлаа. Би цэргийн дүрэмт



хувцсаа цэргийн байрны агуулахад үлдээчихээд явсан нь буруудсан байна лээ. Жаахан харамсалтай санагдсан. Өмнө нь алба хааж байх хугацаандаа тус ангиас их сургуульд элссэн тохиолдол бий дээ? -Тийм ээ. Одоогоос яг нэг жилийн өмнө тус ангийн байлдагч Ц.Билэгжаргал хугацаат цэргийн алба хааж хугацаандаа Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэж, их сургуульд элсэж байсан юм билээ.

Ангийн удирдлагын зүгээс энэ чиглэлд ихээхэн



анхаарсны үр дүн гэж бодож байна. Таны хувьд

... - Тэгэлгүй яах вэ. Энэ жилийн хувьд тус ангиас надаас гадна ахлах байлдагч Э.Жамъянсүрэн Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуульд элссэн. Бид хоёрыг ангийн захирагч хурандаа Ц.Батхүү, мөн ротын захирагч болон бусад удирдах албан тушаалтнууд Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх нөхцөл, боломжоор бүрэн хангасан. Тиймээс ч бид хоёр энэхүү шалгалтаа амжилттай өгч хүссэн сургуульдаа тэнцээд ирлээ. Иймд Та бүхэндээ талархсанаа илэрхийлье. Мөн гэр бүлийнхэндээ хайртай шүү гэж хэлмээр байна. Танд баярлалаа.

Дэслэгч  
М.АНХЖАРГАЛ

# ЭЭРЭГ ХАНДЛАГЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ СУРГАЛТ БОЛЛОО



Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн бие бүрэлдэхүүнд 2023 оны энэ сарын 21-ний өдөр "Аддиктологийн төв"-ийн эмнэг судлаач, сэтгэл судлаач Ч.Гантулгы урьж "Цэргийн алба хаагчид эерэг хандлагыг төлөвшүүлэх арга зам", "Стрессээс хэрхэн урьдчлан сэргийлэх вэ" сэдвээр сургалт зохион байгуулав.

Сургалтаар офицер, ахлагч, ажилтан алба хаагчдаас сэтгэл зүйн сорил судалгаа авч сонирхолтой хөгжөөнт тоглоом, сэтгэл зүй, бие бялдрын дасгал хөдөлгөөнийг хийлгэж, бие бүрэлдэхүүний сэтгэлзүйн байдлыг дээшлүүлэх, хандлагаа өөрчлөх чадварыг олгосон сургалт болсон юм.

Хошууч Д.ЭРДЭНЭСУВД

# ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН БАЯРТ МОРЬТОН ДАЙЧИД УРИГДАВ



Их эзэн Чингис хаанаараа овоглосон Хан Хэнтий аймгийн түүхт 100 жилийн ойн баяр 07 дугаар сарын 26-наас 28-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхээр товлогдоод байгаа билээ.

Энэхүү түүхт ойн баярын ёслолын арга хэмжээнд Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн бие бүрэлдэхүүн уригдаж баяр наадмын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхээр бэлтгэлээ хангаж байна.

О.ЭГШИГЛЭН



Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн түрүүч, байлдагч нар хугацаат цэргийн алба хааж хугацаандаа Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэж, амжилттай өгсний үр дүнд Дотоод Хэргийн Их Сургууль болон Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуульд суралцах эрхийн бичгээ гардсан юм. Тэдний нэг тус ангийн ахлах байлдагч Б.Лхагвадоржийн баярт мөчөөс нь хуваалцсан бяцхан хөөрөлдөөнийг хүргэж байна.

Юуны өмнө уншигчдад өөрийгөө танилцуулна уу?

-Намайг Батбаатарын Лхагвадорж гэдэг. Баянхонгор суманд төрсөн, 19 настай. 2022 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид хугацаат цэргийн алба хааж байна. Та өмнө нь цэргийн алба хаахыг хүсдэг байсан уу? Эсвэл цэргийн зарлан дуудах хуудас аваад гэнэт шийдэв үү?

-Миний хувьд цэргийн алба хааж сонирхол их байсан. Өмнөх оны цэрэг татлагаар буюу өнгөрсөн хавар надад цэргийн зарлан хуудас хуудас ирж тэнцсэн ч сургуулиа төгсөөгүй байсан болохоор намайг чөлөөлсөн. Тэгсэн намрын цэрэг татлагаар надад "зарлан" ирдэггүй. Намайг хотод байх үеэр Баянхонгор суманд цэрэг татлагын комиссын ажил өндөрлөсөн байв. Түүнийг нь би мэдэнгүүтээ хотоос шууд ирээд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб руу орж холбогдох албан тушаалтнуудтай нь уулзаж, цэргийн албыг биеэр хааж хүсэлтэй буйгаа хэлтэл Баян-Овоо суманд "Цэргийн комисс"-ын сүүлийн татлага нь болох гэж байгаа гэсэн. 10 дугаар сарын 10, 11-ний хавьцаа л байсан байх. Тэгээд Баян-Овоо сум руу очоод өөрийнхөө сонирхлоор цэргийн албанд тэнцсэн.

Цэргийн алба хааж буй онцлогийн тухайд ...?

-Жагсаалын бэлтгэл, буудлага, мэргэжлийн бэлтгэл хичээлд хамрагдах сонирхолтой. Сургалт бэлтгэлээс гадна соён гэгээрүүлэх ажил, уралдаан тэмцээн их зохиогдоно. Бидний хэн нэгнээ гэсэн сэтгэл их дулаан. Мөн цэргийн албанд татагдаж ирээд бие бялдар хөгжиж, тэсвэр тэвчээрээс гадна сэтгэлийн хат суудаг юм шиг санагдсан.

Та Дотоод Хэргийн Их Сургуулийн элсэлтийн шалгалтад тэнцсэн сайхан мэдээг бидэнд дуулгасан. Энэ үеийн сэтгэгдлээ хуваалцаач?

-Би цэргийн алба хааж байх хугацаандаа Элсэлтийн ерөнхий шалгалтад эрчимтэй бэлтгэсэн. Ингээд математик, нийгэм, монгол хэлний хичээлээр шалгалт өгсөн. Ингэснээр Дотоод Хэргийн Их Сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хөтөлбөрт 6 дугаар сарын 2-ны өдөр бүртгүүлсэн. Тэгтэл миний мэйл хаагаар 6 дугаар сарын 20-ны өдөр "Та Дотоод хэргийн их сургуульд тэнцлээ. 21-ний өглөө 09.00 цагт ирнэ үү?" гэсэн хариу авсан. Энэ үед сэтгэл их хөдөлж ротын захирагч дэслэгч С.Алдаржавт илтгэсэн. Улмаар ангийн захирагч болон штабын дарга нар дэмжиж надад 6 дугаар сарын 22-ны өдрөөс 7 дугаар сарын 2-ны өдрийг хүртэлх хугацаанд 10 хоногийн чөлөө олгосон. Ингээд ах, эгч хоёрынхоо хамтаар нийслэлийг зорьсон ба би бээр тус сургуулийн элсэлтийн журмын дагуу бие бялдар, сэтгэл зүйн шалгалт болон эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн юм. Улмаар 7 дугаар сарын 1-ний өдөр бүртгэлээ

Гэрэл зураг түүх өгүүлнэ



ЕСӨН ХӨЛТ ЦАГААН ТУГИЙГ ТӨВ ЦЭНГЭЛДЭХЭЭС ТӨРИЙН ОРДОН РУУ ЗАЛЛАА